

НИЙСЛЭЛИЙН НИИТИЙН ТЭЭВРИЙН ГАЗАР,  
НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН  
ХАМТАРСАН ТУШААЛ

2024 оны 01 дугаар сарын 18

Дугаар А/10/А/05

Улаанбаатар хот

Автобус хүлээлцүүлэх ажлын  
хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын А/1216 дугаар захирамж, 2022 оны А/88 дугаар захирамжаар баталсан "Нийтийн тээврийн газрын дүрэм"-ийн 7.1.1, 2022 оны А/75 дугаар захирамжаар баталсан "Нийслэлийн өмчийн харилцааны газрын дүрэм"-ийн 7.1.1-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Нийслэлийн Засаг даргын Тамгын газар болон Тэнүүн-Огоо ХХК-ийн хооронд байгуулсан 2023 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн ННТГ23001, ННТГ23001-1 "Нийтийн тээврийн автобус худалдан авах гэрээ"-ний дагуу нийлүүлэгдсэн дизель хөдөлгүүртэй дунд багтаамжийн болон их багтаамжийн цахилгаан хөдөлгүүртэй автобуснуудыг хүлээлцүүлэх ажлын хэсгийг хавсралтаар баталсугай.

2.Нийлүүлэгдэж буй автобуснуудыг холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмын дагуу хүлээлцүүлэн, акт үйлдэх ажлыг үр дүнтэй шуурхай зохион байгуулж ажиллахыг ажлын хэсэг (Ц.Мягмар)-т даалгасугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийтийн тээврийн газрын Захиргаа, удирдлагын хэлтэс (З.Цэвээндорж)-т, Нийслэлийн өмчийн харилцааны газрын Өмчийн хяналт, ашиглалт, дотоод аудитын хэлтэс (Ц.Цэрэндулам)-т тус тус үүрэг болгосугай.





## АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч:

Нийтийн тээврийн газрын Хяналт шалгалтын хэлтсийн дарга Ц.Мягмар

Гишүүд:

Нийтийн тээврийн газрын Зорчигч тээврийн үйлчилгээний хэлтсийн дарга Б.Дөлгөөн

Нийтийн тээврийн газрын Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Г.Даваадулам

Нийслэлийн өмчийн харилцааны газрын өмчийн менежментийн хэлтсийн дарга М.Энхболд

Нийслэлийн өмчийн харилцааны газрын өмчийн менежментийн хэлтсийн мэргэжилтэн Т.Оюунтуул

Нийтийн тээврийн газрын Хяналт шалгалтын хэлтсийн Автотээврийн хяналтын улсын байцаагч М.Мөнхзул

Нийтийн тээврийн газрын Хяналт шалгалтын хэлтсийн Автотээврийн хяналтын улсын байцаагч Ж.Бум-Эрдэнэ

Улаанбаатар смарт карт ХХК-ийн Талбарын засвар үйлчилгээний хэлтсийн дарга М.Батбилгүүн /зөвшилцсөнөөр/

Нарийн бичгийн дарга:

Нийтийн тээврийн газрын Техник, технологийн хэлтсийн Цахилгаан хангамж хариуцсан инженер Д.Цогтбадрах